

**ЗОХИОЛЧ Д. ЦЭДЭВИЙН “ГАЛ ГОЛОМТ БҮЮУ НУТАГ НУГЫН МИНЬ
ШИВНЭЭН” БҮТЭЭЛИЙН ҮНЭН, УРАН САЙХАН, ГҮН УХААН.**

Г. Галбаяр¹

Удиртгал

Уран зохиол бол уншигчийн сонирхолыг татаад зогсохгүй тэдний үзэл ухамсарт ухаарал бясалгалыг төрүүлж, сэтгэл зүрхэнд нь итгэл найдварыг асааж байдаг зүйл. Уран зохиолын уншигчдад нөлөөлөх энэ увдис чухам юу болохыг үе үеийн утга зохиолын онолын бүтээлүүдэд олон талаас нь тайлбарласаар иржээ. Тэдгээрээс ажиглавал зохиол үнэнийг өгүүлж байж үе үеийн уншигчдын сонирхлыг татаж, окуны хэрэгцээг хангадаг болохыг онцлон өгүүлсэн байна. Үнэн ертөнцөд хамгийн шуларга нийтлэг зүй тогтлыг үүсгэж байдаг тул хүний мөн чанар үнэнийг ямагт чухалчилж үздэг. Аливаа зүйл үнэн байж цаг хугацааны шалгуурыг давж мөнх оршдог жамтай. Ертөнц дотоод мөн чанартаа маш нарийн хаослаг шинжтэй оршдог тул хүний аж амьдрал, ухамсарт төгс зүй тогтолтойгоор мэдрэгддэг. Тиймд аливаа зүйлийн учир холбогдол эрт орой хэзээ нэгэн цагт өөрийн учир зүйндээ заавал орж, учир шалтгаант хийгээд дараагийн өөр бусад зүйлсийн оршин байх бодит үндэс болж байдаг. Энэ бол ертөнцийн бүх зүйл үнэн байж зөв оршдогийг харуулж буй хэрэг. Тиймээс дэлхийн сонгодог утга зохиолын түүхнээ баримтат түүхэн зохиолууд ноёлох байр суурьтай хөгжиж ирсэн юм.

Уншигчдын сонирхол, үзэл бодолд бодит үнэн зүйл үнэ цэнэтэй байх ч тэрхүү үнэнээс урган салбарласан хийсвэрлэл, түүний олон янзын дүрслэлүүд нэн чухлаар үнэлэгддэг байна. Уран зохиол яруу тунгалаг хэл, тансаг сайхан найруулгаар бүтээгдсэн уран сайхан дүрслэлийн цогц хослол учир бодит үнэн үйл хэрэг уран сайхнаар хэлбэржиж байж хүний анхаарлыг татах нь зайлшгүй. Хүний мөн чанар ямагт сайхан руу тэмүүлж байдаг жамтай. Яруу сайхан руу тэмүүлэх тэр тэмүүлэл төсөөлөлд үүссэн амьдралыг уран сайхнаар бичих нь уран зохиол. Иймд уран зохиолд үнэнээс гадна уран сайхны асуудал чухал үнэлэмжтэй.

Хүний аж амьдрал, мөн чанарт ичих түүнээс үүдэлтэй нууцлах шинж мөнх оршиж байдаг. Ичиж, нуух нь хүний бусад амьтнаас ялгарах гол шинж юм. Хүүхэд нийгмийн амьдралд орж эхэлснээр бусдаас ичиж эхэлнэ. Улмаар ичиж байгаа учраас аливаа юмаа бусдаас нуудаг. Энэ үйл хэрэг нийгмийн амьдралд гүн орох тусам гүнзгийрч яваа яваандаа өөрөө өөрөөсөө нууцлах шинжид шилждэг байна. Нууцлах шинж нь хувь хүний хувьд ичихээсээ давамгайлаад ирэхээр эсрэгээрээ тухайн нийгэм түүнээс ичдэг болж хувирдаг. Өөрөө өөрөөсөө нууцлах үйл хэрэг сүүлдээ өөрөө өөрийгөө үл таних үйл хэрэг болж улмаар нийгэм түүнээс ичих үндэслэлийг үүсгэдэг байна. Өөрөө өөрөөсөө нуугаад ойлгохоо байсан тэр зүйлийг, нийгэм түүнээс ичээд байгаа үйл хэргүүдийг уран зохиол уран сайхны аргаар түүнд хэлж, ухааруулж тусладаг. Хүн

1. Монгол Улсын Их Сургууль

Г.Галбаяр

ертөнцийн хамгийн төгс бодгаль учир тэр төгс мөн чанарт хүний мөн чанар, нууц далдын зүйлийг нээнэ гэдэг бол орчлон хорвоогийн учир холбогдлыг нээх, тайлбарлахаас эхэлнэ. Учир нь уншигч зохиолоос баяр хөөр, уйтгар гуниг, жигшил зэвүүцэл гээд хүний амьдралд байх бүх зүйлийг мэдэрч тэр хэмжээгээрээ ухаарал сургамж авч, чинад дотоод туйлдаа өөрөө өөрийгөө нээж байдаг. Зохиолын олон янзын өгүүлэмж, уран нарийн шийдлүүдээр уншигчийн сэтгэл хөглөгдөж олон янзын аялгуу айзмыг өөртөө тоглож байдаг. Сэтгэлийн энэхүү аялгуу хөгөөр дамжуулж уншигчийн далд нууц мөн чанаруудыг өөрт нь таниулж, амьдралд алдах эрхгүй ухаарлыг суулгадаг. Уншигчдад өгөх энэ ухаарлын сэжүүр сэжмийг зохиолч үнэн үйл хэргийг уран сайханжуулсан дүрслэлийн олон холбоос, өрнөлүүдэд шигтгэж урладаг онцлогтой. Аливаа зүйлийн мөн чанар, утга учрыг зохиолын үйл явдалтай уялдуулан тайлбарлах, чимэх, нэгтгэх зэргээр урласан гүн ухааны өгүүлэмжүүд нөгөө талаас нь харвал зохиолын ерөнхий хөрс суурь болж орших нь ч бий.

Үнэнийг уран сайханжуулж, уран сайхныг утгажуулсан төгс холбоос бий болж гэмээ нь тухайн зохиол сайхан, амттай болдог. Иймээс үнэн, уран сайхан, гүн ухааны төгс хослол болсон зохиолыг сайн зохиол хэмээн онолын үүднээс томъёолох бүрэн үндэслэлтэй.

Бид энэ удаад зохиолч Д. Цэдэвийн “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” зохиолыг үнэн, уран сайхан, гүн ухааны хослолын үүднээс задлан шинжилж үзэж байна.

Зохиолч Д. Цэдэвийн “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” зохиол “Уянгын бодрол-намтрын хуудас” гэсэн давхар уялга гарчигтай аж. Энэ давхар уялга гарчиг зохиолч өөрийн намтар түүхийг уянгын халил, бодрол бясалгалын үүднээс уран сайхнаар намтарчлан бичсэн болохыг илэрхийлнэ. “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” зохиол оршил, “Аавын дөрөө түшсэн минь” хэмээх тэргүүн бүлэг, “Доржтой ганзага нийлсэн минь” хэмээх дэд бүлэг, төгсгөлийн үг гэсэн хэсгүүдээр зохиомжлон бичигджээ.

“Монгол орны газрын зургийг дэлгээд харахад зүүн уртрагийн 100°30 1, хойд өргөргийн 46°20 1 солбицох нэгэн цэгт Баян-Овоо хэмээх хөвч хангай, хээр тал, тэрэм говь хосолсон нутаг оршино. Мэдээжээр уудам монгол орны баруун нэгээхэн хязгаар ч гэсэн уужим орчлонгийн хувьд тохмын чинээ бяцхан зай мөн буюу! Энэ орон зай бол ухаан орсон цагаас миний гэсэн шороо, гал, ус, мод, хий, яриагүй л таван махбодийн цогцлол билээ”² хэмээн уг зохиол эхэлж байна. Нийтлэг атлаа өвөрмөц хэв заншил бүхий эгэл зон олон нүүдэллэж, үе дамжин аж төрсөөр ирсэн энэхүү унаган нутаг уснаасаа алсалж, эрдэм номын мөр хөөж явсанаас хойш гучаад жилийн дараа эргэн очиж насан өндөр аав, багын андтайгаа дөрөө харшуулан нутаг орноороо аялж, бага залуу үеийнхээ аж амьдралыг эргүүлэн санаж, аав болоод найзынхаа хууч яриа, бодол сэтгэлээр баталгаажуулан учир холбогдлыг нь уран сайхнаар намтарчлан өгүүлжээ. Тиймээс оршил болгон хүүрнэсэн өгүүлэмжийнхээ төгсгөлд “миний намтрын учрал холбогдол бүхий уянгын бодрол сэтгэгдэл, өвөр дээрээ бөөцийлж өсгөсөн аавын хийгээд үерхэж наадаж байсан үе тэнгийн нөхрийн бодол сэтгэмжээр баяжсаныг хамтад өгүүлсүгэй” (84 дүгээр тал) хэмээн өгүүлж үндсэн хэсгээ эхлүүлээд цааш өрнүүлж, “Унаган төрөлх нутгаараа хэдхэн хоног хөндлөн гүлд явсан атлаа олон он жилийг туулж ухаажсан өвгөн насан аавынхаа ачаар, үе тэнгийн нөхрийн тусгаар нутаг нугаа нээж, бас ч өөрийгөө нээж, өөрийнхөө сэтгэлийг нээсэн” (141 дүгээр тал) тухайгаа төгсгөл хэсэгтээ өгүүлснээр өндөрлөж байна.

1. Монголын уран зохиолын дээжис. СIII (103) боть. Д. Цэдэв Талд нүдэлсэн агь. Уб., 2004. 83 дугаар тал. Жич: Тус өгүүлэлд өгүүлэн буй түүврээс ишлэлүүдийг авсан тул хойшид дор бүрд нь хуудасны дугаарыг тэмдэглэсэн болно.

Г.Галбаяр

I. Зохиолч Д. Цэдэвийн “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн”

бүтээлийн үнэн

Зохиолч Д. Цэдэв “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” бүтээлдээ өөрийнхөө бага залуу насны намтар түүхийг нутаг орныхоо байр байдал, зон олныхоо аж амьдралын олон талын харилцаа холбоонд нь үнэн болитой уран сайхнаар бичжээ. Гэхдээ нэг бүрчлэн дэлгэрэнгүй өгүүлсэнгүй. Өөрийн намтар түүхийг төлөөлөх гол гол хэсгүүдийг хооронд нь уран сайхны үүднээс ямар нэг нарийн сэмжээр холбогдож, бүхэл үеийн амьдралыг төлөөлж чадахуйц онцлогтойгоор дүрсэлж чаджээ. Зохиолч өөрийнхөө мэдэх үеийг уран сайхнаар ургуулан баяжуулж дүрсэлсэн бол өөрийнхөө мэдэхгүй үе болох төрөх хийгээд нялх үеийнхээ амьдралыг аав болоод тэр үеийн тухай сайн мэдэх өтгөс буурлуудын нэхэн дурссан дурсамжид тулгуурлан өгүүлсэн байна. Бага залуу насныхаа намтар түүхийг хүн төрөлхтний аж амьдралын утга учир, хорвоо дэлхийн мөн чанарыг таниж, юм үзэж нүд тайлсан хижээл насны өндөрлөг, эрдэм ухааны цогц хослолоос өгүүлсэн нь нэн сонирхолтой төдийгүй сургамжтай юм.

I.I. Зохиолчийн аж амьдралын онцлог хийгээд намтар түүхийн үнэн

“Арван зургидугаар жарны цагаан луу жилийн намрын дунд сарын гүн шонө харлах тэнгэрийн дор гурван гэр зүүрмэглэх мэт байв. Чандмалан буусан гурван гэрийн дунд хотолсон хонин сүрэг ч эздийнхээ нэгэн адил үнэгэн харанхуй үеийн өтгөн нойрт дарагдсанаас орчин тойрон тийм нам гүм ажээ. Эл нам гүм агаад гүн харанхуйн мөч бол орчлонгийн нэгэн шинэ үүр гэгээрэх дөхөж бийгаагийн шинэж, хорвоод нэгэн шинэ хүнийг хүлээж авах ойртсоны дохио болно” (84 дүгээр тал) хэмээн өөрийгөө хэзээ, хаана төрсөн тухайгаа байгаль ертөнцийн хууль жам, зүй зохистой хослуулан өгүүлснээр уг зохиол эхэлж байна. Хорвоогийн нэгэн шинэ өглөөтэй дуу харшуулан мэндэлсэн бяцхан хүүгийн дуудах нэрийг хэрхэн өгсөн тухай *“Хүүгийн эцэг, хадаг хоёр гардан барьж “хүүхдэд нэр хайрла” хэмээн хүсэхэд гэрийн хойморт завилан суусан лам судар сохон үзэж “Цэдүб” гэсэн нэрийг сонгон залуу эхийн чихэнд шивнэв. Залуу эх хүүгийнхээ баруун чихэнд “Цэдүб” гэж гурвантаа шивнэв. Түүний дараа хүү “Буйн бүтэх, насан бүтэх” гэсэн утга бүхий “Цэдүб” гэсэн төвд нэртэй болсныг олонд сонордуулах нь тэр болой”* (86-87 дугаар тал) гэж өгүүлжээ. Энэ нь тухайн үеийн монгол айлын хүүхдэд нэр өгөх ерөнхий жишгийн дагуу хэдий ч өөрийн гэсэн онцлогтой нэртэй болсон тухайгаа аавынхаа хуучилсан хууч ярианы үнэнд тулгуурлаж өгүүлсэн хэрэг.

Жаалхүү Цэдэв үе тэнгийн хүүхдүүдийн нэгэн адил төрсөн гэртээ аав ээжийнхээ хайр халамжинд өсөн торниж, хүмүүжин ухаажиж байсан ч таван настайд нь нөхөж барахгүй гай барцад тохиож сэтгэл зүрх, аж амьдрал нь гүн хар голбоор будагджээ. Зохиолчийг таван настайд ээж нь идэр залуугаараа ертөнцийн мөнх бусыг үзүүлж, хагацал зовлонгийн туйлыг амссан нь тэр аж. Зохиолчийн амьдралд тол ул мөрөө үлдээж, баяр жаргал, хайр халамж гээд бүх сайхан бүхнийг нь авч одсон болохоор энэ үеийн тухай зохиолд нэлээд дэлгэрэнгүй бас харуусал дүүрэн өгүүлсэн байна. Сэтгэлийн гүнд нь олон жил хадгалаастай явсан гунигт үйл хэрэг учир ар араасаа хөврөн тэр үеийн үнэн дүр зураг уран сайхны хэлээр амилсан нь тэр буй за. Тухайлбал, хайрт залуу эхийнхээ алтан шарилтай салах ёс гүйцэтгэж үүрд өнчирч хоцорсон тухайгаа *“би хөмөрсөн аргин дээр гарч эхийнхээ шарилын хойноос зүрхэндээ хагацлын хар нулимс асгаруулан бараа тасартал ииртсэн сэн”* (97 дугаар тал) хэмээн уншсан хэн хүний сэтгэл сэмэрч, самсаа шархирам дүр зургийг тухайн үеийн гашуун үнэнд тулгуурлан өгүүлсэн байна. Хэлж ирэхгүй хийсч ирэх энэ хагацал ертөнцөд төрсөн хүн бүрийг дайрах нь үнэн ч зохиолч тэр нийтлэг үнэнг өөрийнхөө амьдрал дахь цагаасаа эрт тохиосон харууслаар тодотгон ганцхан өөрийнхөө үнэн болох үүднээс нь тодруулан өгүүлсэн нь магадгүй хүний сэтгэлд

Г.Галбаяр

илүүтэй хүрсэн биз. Учир нь хүн өөрөөсөө илүү бусдыг илүү сонирхож, бусдын амьдралыг сонжиж амьдардаг онцлогтой холбоотой.

“... Нэг л мэдэхэд нар хананы элэг рүү бууж бага үд болчихсон байна. Би унтаад орондоо ганцаар хоцорчээ. Босоход миний омсох хувцсыг орны урд тавьж, шалны өрөн дээр идэх ааруул, ёотон, ором ялгаж үлдээжээ. Аавын зэхэснийг идэж зугаад би ор дэвсгэрээ хураана. Гэрээ цэвэрлэнэ. Тэгээд л гадаа хатавчаа түшиж нарлаад суучихна. Миний дэргэд “Асар” нэрт улаан халтар нохой оцойж шил шиг тунгалаг нүдээ гялалзуулна. Би түүнтэй өдөржин эрхлэнэ. Заримдаа наранд халууцан зүүрмэглээд улаан халтарыгаа түшээд унтчихсан байдагсан. Аавын айсуйг Асар ч андахгүй. Асарыг гийнэн хуцахад алсаас аав ирж явна. Тэгээд л барааны газраас Асартайгаа уралдаад л гүйчихнэ. Аав намайг харуут мориндоо ташуур өгч ирээд л эмээл дээрээ дүүрч гэртээ авчирдагсан. Асар ч хүлгийн дөрөө жолоо долоож, моринд өшиглүүлэх шахна. Би ч аавынхаа эгэмд толгойгоо наан өвөр дээр нь түгдийн хярна. Тэр үед аавын өвөр дээр суух шиг жаргал надад байгаагүй” (100 дугаар тал) гэж өнчирч хоцорсон өөрийнхөө зовлон, жаргалыг түүхэн бодит үнэнд тулгуурлан уран сайхны үүднээс хүний сэтгэлд гүн хоногшиж үлдэм дүрсэлжээ. Монгол малчин айлын ажил албаны хуваариар гэрийн доторх ажлыг гэрийн эзэгтэй, гадуурх ажлыг гэрийн эзэн гүйцэтгэх жамтай юм хойно аав нь адуу малын эрэл, амьтан хүнтэй уулзах гээд эх захгүй алба ажлынхаа үеэр хүүгээ өөрөөс хамаарах бүх зүйлээр асарч тордон үлдээх ч эхийн хайр халамж, үүргийг тэр бүр орлож эс чадна. Энэ үед л эхгүй өнчин байхын бэрхшээлийг сэтгэл зүрхэндээ уустал ойлгож байсны хувьд дээрх зураглалыг бичсэн нь тодорхой. Эхгүй өсөхийн зовлонг эцэгтэй байхын жаргалаар нөхөж асан үедээ “Ээждээ зэмлүүлж, тэр ч байтугай зодуулж байгаа хүүхэд, багачуулыг харихад “яасан азтай вэ?” гэх бодол төрдөгсөн.” (99 дүгээр тал) гэж үнэнийг өгүүлсэн байна.

Зохиолч бага балчир насандаа эхээсээ өнчирч хоцрон зовлон бэрхийг туулсан ч эцгийн хайр халамж, нутаг орны зон олны өмөг түшиг, зан заншлын уламжлал гээд олон сайхан зүйлийн дунд зөв хүн болж өссөн азтай нэгэн аж. Түүний аав Дожоо нь нутаг орондоо алдартай дуучин хүн байж. Нутаг орон нь төв халхын уртын дууны өлгий. Энэ нутгийнхан намар намрын дэлгэр цагаар уртын дууны наадам хийж, хэн олон дуу мэдэж сайхан дуулахаараа өрсөлдөх ч утгаа бол уртын дууг сурах, хойч үедээ өвлүүлэх сургалтыг зохион байгуулдаг уламжлалтай ажээ. Нарийны голд таана хэнээлж ер бусын урт сайхан намар болсон тэр нэг жилийн уртын дууны наадмын тухай зохиолд дэлгэрэнгүй өгүүлжээ. Тэр наадамд бяцхан хүү Цэдэв аавыгаа даган очжээ. Хурсан олон талцан сууж ээлжлэн дуулах ч нэг дууг тухайн наадамд давтан дуулах ёсгүй гэнэ. Дуулах дуугүй болсон нь суудал доошилж, дуулах дуутай нь суудал дээшилдэг шуларга тэр тэмцээний тухай “Гэрийн тооноор харахад нар жаргаж л байлаа. Нэг л мэдэхэд сар мандаж л байв.” (106 дугаар тал) гэж урнаар үнэнийг өгүүлсэн байна. Уртын дууны аяар бүүвэйлэгдэж, утгаар нь ухаарч өссөний хувьд “Дуугаар амилсан ертөнц намайг бүрнээ эзэмдэж нүдийг минь нээсэн юм.” (107 дугаар тал) гэж өгүүлсэн нь аргагүй биз. Тэр ч утгаараа уртын дууны тухай “Уужим тал, мөнхрөн цэлийх тэнгэрээ дагаж монгол хүний сэтгэлийн аясаар уртын дуу хөврон гарсан байж ч юуны магад” (108 дугаар тал), “Уртын дуу зүрхнээс гарч зүрхэнд шингэх удистай” (109 дүгээр тал) хэмээн өөрийн үзэл бодлыг чухам үнэнээр өгүүлсэн нь уртын дууны судлалд чухал ач холбогдолтой.

Зохиолч өөрийнхөө хэрхэн төрж өссөн хийгээд ухаажсан үнэнийг энэ мэтээр өгүүлсэн нь зөвхөн тухайн зохиолчийн амьдралын үнэн боловч энэ үнэн уншигч олны аж амьдралын нийтлэг үнэний хэв загварыг хадгалснаараа үнэ цэнэтэй юм.

1.11. Ертөнцийн аж амьдралын үнэн хийгээд зохиолчийн нутаг орны онцлог

“Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” зохиолд зохиолч өөрийн бага насны намтар түүхийг үнэн бодит байдлаар нь уран сайхны үүднээс хүүрнээд зогсоогүй төрж өссөн нутаг орон, хорвоо ертөнцийн үнэн мөнгийг өөрийн амьдралтайгаа холбон урласан онцлогтой байна. Хүн эхээс төрөөд эх газартай ертөнцийн татах хүчний хуулиар гүн холбогдож, хүн болох ухаан, аргыг сурдаг тул анх төрсөн газраа “*унасан газар, угаасан ус минь*” хэмээн ихэд хүндэтгэж сүслэн дээдэлж явдаг нь нарийн учир утгатай. Тиймд зохиолч Д. Цэдэв “*Нутаг нуга юугаа үгүйлэж, бас ч газар усандаа үгүйлэгдэнэ гэдэг унаган үрийн аз заяа аргагүй л мөн буюу*” (83 дугаар тал) хэмээн дуун алдаж, нутаг үр хоёрын бие биенээ үгүйлэх, санах, бие биенээ дээдлэн хүндэтгэх жам, мөн чанарыг:

Аав л ээжийн нутагтаа

Алаг үрийн сэтгэл уяатай

Алаг үрийн сэтгэлдээ

Аав л ээжийн нутаг уяатай... (83 дугаар тал) гэсэн ардын дууны үнэн утга агуулгаар баяжуулан баталгаажуулж өгүүлсэн нь нарийн урлал болжээ. Улмаар он удаан жилийн дараа төрсөн хүүгээ тосож авсан нутаг хүүгийнхээ сэтгэлд “*бага залуу үеийн дурсгал дурсамж бүхнийг хадгалсан агаар тэнгэр, ус урсгал, хөрс шороо, өвс ургамал нь хүртэл надтай ярьж, сэтгэл зүрхэнд олныг шивнэж*” (84 дүгээр тал) буй мэт сэтгэгдэл төрүүлжээ. Нутаг гэдэг учиртай, үр гэдэг сэтгэлтэй. Үүнд л төрсөн нутгийн ид шид, утга учир, төрүүлсэн хүүгийн ухаан, итгэл сэтгэл оршдог биз ээ.

Зохиолч Д. Цэдэв уг зохиолдоо төрсөн нутгийнхаа тухай эндээ ийм сайхан уул устай, гэндээ тийм өндөр хайрхан даваадтай, хүн мал нь ингэж багшран байдаг зэргээр өгүүлэлгүй тэр газар нутгийн төрүүлж өсгөсөн хүн зон, мал сүргийн онцлог, төлөвшил зэргээр дамжуулан нутгийнхаа үнэн бодит байр байдлыг дүрсэлсэн нь тухайн зохиолын зохиомжийн нарийн онцлог, зохиолчийн уран арга, туршлагыг харуулна. Зохиолчийг нялх багад нь эхийн сүүнд цадахгүй байх үед хажуу айлынх нь эгч өдөр ч, шөнө ч ялгал үгүй орж ирэн хөхүүлдэг байсан тухай үнэнийг нэхэн өгүүлсэн байна. Мөн зохиолчийн нутагт “Хундан” Бадам хэмээх эр залуу идэр насандаа сайн эрийн замналаар замнаж яваад ардын засгийн үйл хэрэгт туслаж хожим шагнагдсан ч баярлаж хөөрсөн зүйлгүй хийх ёстой зүйлээ хийсэн мэт амьдарч насыг илээсэн тухай, өөрийн унаган Хулан хонгор хэмээн нутаг орондоо алдаршсан сайхан хүлгийн тухай бичихдээ түүхэн бодит үйл хэргүүдтэй холбон тэдгээр сайхан хүмүүс, хүлэг морины эрдэм чадлыг товойлгон дүрсэлсэн байна. Өөрийг нь хөхүүлж өсгөсөн сайхан сэтгэлт эгч, “Хундан” Бадам болоод Хулан хонгор морины домог түүх нь энэ нутгийн нэгэн үеийн түүхийг хүүрнэж байна. Өөрөөр хэлбэл зохиолч төрсөн нутаг орноо эзэн хүмүүс, эрэмгий хүлгээр нь товойлгон ийм сайн хүмүүс, сайхан хүлгийг төрүүлж чадсан нутаг гэдэг уул ус, ургамал ногоо, агаар тэнгэрийн төгс зохилдлогоо бүрдсэн нутаг болохыг өгүүлжээ.

Зохиолчийн төрсөн нутгаас хоёр өртөө зайтай орших ч зүрх сэтгэлд нь гүн ул мөрөө үлдээсэн Шаргалжуутын рашааны дүр зураг, түүх домог, эмчлүүлэгч хүн зоны аж амьдрал уг зохиолд бодитой дүрслэгдэн үлджээ. Түйн голоос гүн ус гаталж үзээгүй балчир багадаа үл хөдлөх болсон баруун гараа энэ рашаанаар эмчилж эдгэрсэн тул Шаргалжуутын рашааныг өөрийн намтар түүхтэй салшгүй холбоотой хэмээн үзэж зохиолдоо өгүүлэхдээ цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөн хувирч байгааг бахархах халагдахын заагаар илэрхийлсэн нь уншигч хэн бүхэнд нэгийг бодогдуулна. Бяцхан хүү аавыгаа дагаж, өвчиндөө шаналж Шаргалжуутад очоод тухайн рашааныг анх яаж нээсэн тухай асуухад тэрхүү рашааныг сахин хамгаалагч Сономжанцан гуайн домогчлон ярьсныг аав нь “*Хэдийд ч юм бэ, Анчин эр арван салаа эвэртэй хангал буга агнадаг байж дээ, Залуу эрийн ширхдуулсан буга зам буруулан алга болсноо*

Г.Галбаяр

төдөлгүй эдгэрчихсэн таарч гэнэ. Анчин гайхаж дараагийн нэг шархадсан бугыг мөрдөхөд цусаа дуслуулан явсаар өтгөн уур манан савсан газар тийш орж бараа тасарчээ. Тэнд тогтоол усанд хэвтэж байгаад буга ой хөвчөө тэмцэн алга болсон гэнэ. Түүнийг ажсан анчин эр эсгэсэн хуруугаа тэрхүү усанд дүрэхэд үлгэрт гардаг “Үд хүрэлгүй эдгээдэг үрлэн цагаан эм, хоног хүрэлгүй анагаадаг хорголжин цагаан эм” мэт л дорхиноо шаар болж дээ. Чингээж л Шаргалжуутыг анх нээсэн гэдэг” (134 дүгээр тал) хэмээн өгүүлж байсныг үнэнээр нь бичжээ. Энэ хэдийгээр домог боловч тухайн нутгийн ард олон ач тустай рашаан усаа хэрхэн анх нээж олсон тухайгаа эрхэлж байсан аж ахуйтайгаа холбон уран сайханжуулан өгүүлсэн нь туйлбаргүй үнэн. Нөгөө талаас байгаль эх өөрийн төрүүлсэн хүн амьтныг эрүүл саруул, аз жаргалтай байлгах үүднээс эмчлэх анагаах зүйлийг нь хүртэл бий болгож байдаг тухай буюу ертөнцийн бүх зүйл харилцан уялдаа холбоотой, бие биенийхээ оршин байх арга болж байдаг бодит үнэнийг харуулсан хэрэг. Зохиолд Шаргалжуутын рашааны дүр зургийг “наран ээвэр налуу энгэрт битүү уур манан савсаж түүний завсар сиймхийгээр халуун хүйтэн рашаан аягаар хутган амсаж ууж яваа онго онгийн дээд дэвээтэй улс зон хад асганаас нь хавьгүй олон” (133 дугаар тал) гэж өгүүлэхдээ уг рашааны эмчилгээний чанар онцгой тул зорин очих хүмүүс маш олон болохыг онцлон товойлгож дүрсэлсэн нь бодит байдалтай яв цав дүйх аж.

“Монгол нутгаас олдсон Согд бичгийн цорын ганц том дурсгал” /Ортенбург Баян-Овооны Хөшөөтийн хөндий дэх хүн чулууны бичээс, түүний тайлбар/ хэмээн үнэлэгдсэн Баян-Овоо сумын нутаг Хөшөөтийн хөндийд орших хүн чулууны тухай гайхамшигтай хийгээд гашуун үнэнийг бодитой бичсэн нь хойч үеийн хүмүүст сургамжтай үйл хэрэг болжээ. Уг хүн чулууны тухай гайхамшигтай гэдэг нь “алив нэгийг бодлогоширох мэт хоёр гараа элгэндээ зөрүүлэн зогсох” (136 дугаар тал) эл хүн чулуу эрт урьд нэгэн цагийн намтар түүхийг хадгалан цаг хугацааг түүчээлэн оршиж буй хэрэг. Тиймээс зохиолч “Хүн чулууг эртний нэгэн цагт чулуунд хувилсан намтар, нүгэн буяныг тодоогох цагийн гэрч, ухаан тайлаас зохих ухаан эрдмийг уралдуулагч оньсого хэлсэн сананал” (136 дугаар тал) гэж онцлон өгүүлсэн нь санамсаргүй хэрэг бус бололтой. Тэр дундаа энэ Хөшөөтийн хөндийн хүн чулуу бол Согдын үеийн үнэг дурсгал байжээ. Гашуун үнэн болоод дээрх өгүүлбэрийг өнгөрсөн цагт байжээ гэж өгүүлсэн нь уг үнэг дурсгалыг өнөө маргаашийн ашиг хайсан богино ухаант нэгэн сүйтгэж үгүй болгосон хэргээс болсон юм. Хүн чулууны сүйрлийн гол шалтгаан нутаг орныхны дунд дэлгэрсэн “хөрсөн гүнд нь маш их алт эрдэнэс булж түүний харуул болгон хүн чулууг сийлж дээр нь утга учрыг бичсэн” (137 дугаар тал) гэсэн домог хуучаас эхтэй аж. Нутаг орондоо эзэн болсон ухаант буурлууд үнэ цэнэтэй ховор нандин зүйлээ хайрлан хамгаалж дараа дараагийн үед бодит байдлаар нь хүлээлгэн өгөхийн тулд элдэв уран сайхан домог зохион түүгээрээ нутаг орныхоо тэр үнэгт зүйлийг дархлан хамгаалах арга болгож “Хөшөө чулууг та нар оролдов оо. Оролдовол тэнгэр бурхан хилтэнэдэг юм шүү” (137 дугаар тал) гэж сүсэг бишрэл, үзэл санаанд нь дархлаа болгон суулгаж ирснийг өнөө цагийн ухаан мунхаг, шунал ихт бэлэнчлэх сэтгэлгээтнүүд устгаж үгүй хийснийг халаглан өгүүлсэн нь өнөөгийн ороо бусгаа цагийн салхинд хүний мөс чанар, үзэл бодол, сэтгэл зүрх хэрхэн хувирч өөрчлөгдөж буй үнэнийг давхар давхар илэрхийлсэн хэрэг.

Зохиолын төгсгөлд найз Доржийн хамт нутгийн нам гүм шөнийг харж “Би их хотын дүүргээс тэнгэрийн зулай хавийн оочин цоочин хэдэн одыг хардагсан. Бусад оддыг бараг мартаж дохжээ. Мартаж бүхнээ сэргээж насан багын олон одтойгоо энэ шөнө ахин учрав. Энэ бол унаган нутгийн нам гүмхэн шөнийн надад хайрласан үнэгт бэлэг буюу” (140 дүгээр тал) хэмээн олзуурхан онцлон өгүүлсэн байна. Энэ олзуурхал бол шинэ амьдрал, шинэ эрч хүч, шинэ ухаарлыг олсон үнэн.

Г.Галбаяр

II. Зохиолч Д. Цэдэвийн “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн”

бүтээлийн уран сайхан

Уран зохиол бол үнэнийг уран яруу бичих, уран яруугаар дамжуулж утга санааг нээх урлаг. Хүний мөн чанар үнэнийг ямагт чухалчилж үздэг. Үнэн дангаараа байж гэмээ нь уран зохиол бус. Үнэнийг уран сайханжуулсан нь уран зохиол. Зохиолч Д. Цэдэв “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” бүтээлдээ өөрийн түүх намтрыг уран сайхны хэлбэрт буулган зохиомж хийгээд дүрслэлийн сонирхолтой аргуудын хослолоор яруу сайхан урласан байна. Энэ нь Д. Цэдэв гэдэг хүний бага залуу цагийн намтар түүхийн урлал болоод зогсоогүй ерөөс монгол хүний аж амьдрал, намтар түүхийн нийтлэг онцлогийг баримтаг уран сайхны аргаар хүүрнэхийн төлөөлөл болжээ. Тиймд эл зохиол монголын уран зохиолын түүхнээ чухал байр эзэлнэ. Уг бүтээлийн энэ онцлогийг олон талаас нь судлан шинжлэх нь нэн чухал юм.

II.1. Зохиолч бага насныхаа намтар түүхийг уран сайхнаар дүрсэлсэн нь

Зохиолч Д. Цэдэв “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” бүтээлдээ бага насныхаа түүх намтрыг уран сайханжуулан бичсэн тул түүний аж амьдралтай холбоотой олон хүн, олон зүйлийн дүр зураг хоорондоо нарийн холбоо хамааралтайгаар дүрслэгджээ. Юуны өмнө өөрийнхөө аж амьдралыг эхийнхээ хайр халамжтай холбон дүрсэлсэн тул үрээ гэсэн эхийнх нь сэтгэлээр түүний бага балчир цагийн амьдрал төвийн харагдаж байна. Орчлонд эх хүн үр хүүхдээ төрүүлнэ гэдэг сэтгэлийн гүндээ баяр баяслаар бялхах ч биесийн хувьд өвдөж зовохын туйлыг үзнэ. Үүнийг зохиолд “*Чухам энэ мочид эхийн алганд хаши чулуу таарсан бол элс шороо болтлоо үйрсэн байж таарна*” (85 дугаар тал) хэмээн уран сайхны хэтрүүллийн дүрслэлийг зөв газар чадварлаг ашиглан өгүүлжээ. Улмаар зохиолч өөрийнхөө бага настай уялдуулан идэр залуу цагтаа энэ орчлонгоос халин олсон эхийнхээ дүрийг урнаар урлан дүрсэлсэн байна. Бага залуу насандаа хүний хань, хүүхдийн эх болж хожим ханьдаа “*Чиний ээж бид хоёр ч айл гэр болж үртэй болсон болохоос өөрсдөө хүүхдээрээ шахуу байж дээ. ... Бага залуудаа ханилсан болохоор миний элэг зүрхэнд ээж чинь ... сэтгэл ив үсрээх юм*” (99 дүгээр тал), үрдээ “*ээжийнхээ өнгө зүсийг дуурайж чандаагүй ч өр зүрхний сайхнаас бага ч гэсэн авсан бол боллоо*” (99 дүгээр тал), нутаг нугын олондоо “*энэ хүүгийн ээж манай нутаг нуруундаа ганц цэцэг нь байсан юм шүү. Тийм цэвэр бүсгүй орчлонд даанч ховор төрөх юм даа.*” (99 дүгээр тал), “*Энэ хүүгийн ээж хонгор морийг бага залууд нь унаж явахыг нэг удаа харсан. Хорвоод ховор төрсөн хүн, адгуус хоёр биесээ яаж олж ижилсээ вэ? гэж бодож байсан*” (116 дугаар тал) гэх зэргээр үнэлэгдэж байсан тухайг богино амьдралынх нь дэлгэр үйлээр сэлбэн дүрийг нь урлан үлдээжээ. Иймд уг дүр монголын уран зохиолын Зохиолч төрсөн нутагтаа очиж, төрсөн гэрийн буурин дээрээсээ дээшээ харвал “*мөнх хөх тэнгэр бодол шиг хязгааргүй цэв цэлийн*” (89 дүгээр тал) харагдаж байгааг өгүүлсэн нь сэтгэлийн гүн дэх бага насныхаа түүх намтрыг өнөө цагийнхаа ухаарал бодролтой харьцуулан амьдралынхаа утга учрыг ойлгож ядан байх дүр зургийг хязгааргүй өнө мөнхөд үргэлжлэх хөх тэнгэрийн мандалтай жишиж нэгээс нөгөөг ургуулан, нэгийн харьцаанд нөгөөг уусган ухаарсан уран дүрслэл аж. Улмаар гутлаа тайлан хөл нүцгэн алхаж үзээд:

Өргөс битгий хэл

Хадаас нэвтлэмгүй

Зузаан ултай байсан хөл

Өндөр нам өсгий

Өргөн нарийн ороолтоор

Үргэлж хулдуулахдаа

Г.Галбаяр

Үжиршдэг юм биш байгаа?

Байгалийн хүрээлэн дундаа

Байнга сэлж явни гээж

Бодсоор байгаад бид чинь

Баян дэлгэр орчиноосоо

Элдэв зузаавчаар

Алслан холдсоор

Байгаа юм биш байгаа (90 дүгээр тал) хэмээн халаглан шүлэглэжээ. Хүн байгальтайгаа ойр л байгаад байх юм бол байгаль өөрийн үр садаа эрүүл саруул, аз жаргалтай байлгаж байх мөн чанартай ч хүн байгалиас илүү сайхан, илүү тав тухыг мөрөөдөж илүүг эрэлхийлэн тэр бүхнийг бий болгох ч тэр хэрээрээ байгалиасаа холдож, тэр нь угтаа бол сайхан биш муу муухайн уг үндэс болж байдаг үнэнийг урнаар өгүүлжээ. Амьдрал гэдэг хүнд ухаарлыг ямагт бэлэглэж байдаг. Тэр ухаарлыг уран бүтээлч хүн илүү таньж мэддэг жамтай нь энэ буюу.

Аливаа хүний амьдралд эх эцэг, төрсөн нутаг орон онцгой чухал үүрэгтэй байдаг тул зохиолч өөрийн бага залуу цагийн намтар түүхийг бичихдээ ээж аавынхаа хайр энхрийлэл, төрсөн гэрийн буурь, төрсөн нутгийн уул ус, ургамал ногооны тал талын хүрээ хамааралд ийнхүү урнаар өгүүлсэн нь өвөрмөц дүр дүрслэлийг бүтээжээ.

III. Зохиолч нутаг нугынхаа онцлогийг уран сайхнаар дүрсэлсэн нь

Зохиолч төрсөн нутагтаа очиж байр байдлыг нь сонжоод багын бодол санаатайгаа харьцуулан *"Өндөр байсан уулс өвгөрөн авичаад намхан бэл толгод болдоггүй байгаа. Улаан дэл хавцгай цагийн эрхээр өсөж өндийгөөд өндөр уулс болдоггүй байгаа"* (88 дугаар тал) хэмээн өөрөөсөө асуугаад *"Үгүй ээ! Довцог толгод, дэл хавцгай өндөр уулс шиг бус, өргөн талынх шиг бус өөртөө л таарсан нүүр царай, хэл яриатай"* (88 дугаар тал) гэж өөртөө хариулсан тухайгаа өгүүлжээ. Зохиолчийн бие өсөж хөгжин өөрчлөгдөж, ухаан санаа гэлж сэтгэсний адил унаган нутаг орныхоо уулсыг хүртэл өсөж том болоосой гэсэн хүсэл мөрөөдлийг илэрхийлсэн ч ертөнцийн уул усанд тийм боломж үгүй, тэр нь оршин байх, утга учиртай, увдис шидтэй байхын үндэс болохыг далд битүү уран дүрслэлээр дамжуулан илэрхийлсэн нь гайхалтай.

Зохиолч аав болоод найзын хамт нутаг усаараа аялж явахдаа нутгийнхаа дүр зургийг уран сайхан буулгасан нь олон. Тухайлбал, нутаг орныхны дунд *"тэмээн сүргийн бэлчээр"* хэмээн алдаршсан Хонгорын тал дундуур хатируулж явахдаа тэр сайн нугаа *"Тэнгэрийн хаяатай залган дуниартсан их талд нуур далайн давалгаа үе үе цалгилах шиг зэрэглээ дивлан савлах ажээ"* (105 дугаар тал) хэмээн мал сүрэг, хүн зон нь налайсан их талын зураглалыг үгээр урласан бол *"Дорж бид хоёр адуутайгаа хамт тэнгэрийн оддыг манаж хээр талд явахуйд зөөлөн салхи сэвс сэвс үлээж таана хүмү үлийн хурц ааг, адууны нялуувтар үнэртэй холилдон хамар цоргиж байдагсан. Холын оддын чимээ сонсдом нам гүмийн дунд өвс ногоог адууны шижигнэтэл зулгаах, тургилах, алсын анир авангаа янцгаах үе үе сонсдоно"* (139 дүгээр тал) гэж адуу бэлчиж, айлууд амарсан тал нутгийн амгалан шөнийг урнаар хүүрнэн өгүүлсэн нь бий. Нутгийнхаа саруул уудам сайхныг хүн малынх нь аж амьдралтай холбон гэрэлт шар нартай гэгээн гунгалаг өдрийн өнгөөр нь одод ярайж, орчлон амарсан нам гүм шөнийн зураглалаар ертөнцийн хаана ч байхгүй амар амгалангийн цогцлолыг бүтээсэн нь гайхам.

Ийм саруул тал, ийм уудам тэнгэрийн дор их хүн төрж, их амьдрал өнө мөнхөд өрнөдөг нь жам.

Г.Галбаяр

Нутаг орныхоо дүр зурагтай уялдуулан эгэл энгийн ч онцгой содон амьдралыг гуулж, нутаг орныхоо нүүр царай болсон хүн. малын тухай дэлгэрэнгүй өгүүлсэн нь цөөнгүй. “Эрийг нас дардаг. Уулыг нас дардаг гэдэг үнээн. Миний сайн эр явсны дурсгал энэ л гялаан сорви болж үлдэв шив дээ” (113 дугаар тал) хэмээн хэв нэг ярьж суух Бадамыг нутгийнхан нь цагаан шар царайтай болохоор нь “Хундан” хэмээн хочилдог аж. Залуудаа “эрийн сайнаар хошуу дамжиж, морины сайнаар холыг туулж” сайн эрийн замналаар замнаж эрийн жавхаа, идрийн хүчээ гайхуулж явахдаа буруу санаатын бууны суманд малгайн дорх дагзаа сэт зуруулан өнгөрсөн нэгэн. Хожмоо нутаг орныхоо хүүхэд залуусын үлгэр дуурайл болон төлөв даруу амьдарч, тэдний хүмүүжилд хамжаар хантайрга болсон түүнийг зохиолд “Тэрхүү Хундан Бадам бол ондор мундаатай хүрэн морь унаад хоёр хөл нь газар шүргэх шахам савлаж явдагсан.” (111 дүгээр тал) гэж өгүүлэн буй хэсгийн эхэнд өөрийнхөө хийсэн үйл хэрэгтэй уялдуулан, дүр зургийг нь урлаад төгсгөлд нь “Миний аавын үеийнхэн ийм л эр зориг, тэсвэр хатуужил, өгөөмөр сэтгэл, даруу төлөв зан цогцолсон хүмүүс явж дээ” (114 дүгээр тал) хэмээн дотоод мөн чанар руу нь гүн өнгийн дүрсэлсэн байна. Энэ хүнийг онцлон өгүүлсэн учир нь Хундан хэмээх хочиг Бадам бол зохиолчийн болоод тухайн үеийн хүүхэд залуусын хүмүүжил, ажил хөдөлмөрийн үлгэр дуурайл болсон нэгэн байсанд оршино. Сайхан нутгаас сайн хүний зэрэгцээ сайн хүлэг төрдгийн жишээ баримт болгож аавынхаа Хулан хонгор морины дүр зургийг онцлон өгүүлжээ. Нутаг орныхныхоо дунд газар товчилдог Хулан хонгор хэмээн алдаршсан сайхан хүлгийг аав ээжийнхээ үйл амьдралтай холбон өгүүлээд эцэст нь:

Наран цацраг шингэсэн талдаа

Намайг явгалж хаячихаа нь үгүй

Найман ганзага хаялан хатирах

Насны итгэл хулан хонгор

Хангал насанд жигүүр нэмсэн хүчтэй

Хараа бодлыг минь сунгаж өгсөн ачтай

Дэнжийн горхи буцалмаар халуунд

Дэлэн дээрээ хөлөргөө нь үгүй

Мяндсан жолоог сунган хатирах

Мянганы манлай хулан хонгор минь

Ургах насанд жигүүр нэмсэн хүчтэй

Ухаан санааг минь задалж өгсөн ачтай

Элбэг булаг харзалмаар жаварт

Эмээл дээрээ жиндүүлээ нь үгүй

Түүрүү саихийг орхин хатирах

Түмний дуртгал хулан хонгор минь

Ундрах насанд жигүүр нэмсэн хүчтэй

Урам зоригийг минь бадрааж өгсөн ачтай (118 дугаар тал) хэмээн шүлэглэсэнд монголын нэрт хөгжмийн зохиолч Г. Дарамзагд ая хийж, монголчуудын дунд морины гэж алдаршсан дуучин Ж. Нансалмаагийн дуулснаар Монголын радиогийн алтан фондоод мөнхрөн үлдсэн түүхтэй. Зохиолч Хулан хонгорынхоо дүрийг урлахдаа эзэн хүндээ ээлтэй эх нутагтаа чимэгтэй итгэлт энэ хүлэг найман ганзага сугартал, нарийн өвс сугсартал хаана ч хүртэл эцэж цуцахгүй хатирах хурд хүчтэй сайн ажнай тул түүнийг унаж явахад өвлийн цагт даарах хөрөхийн зовлонг, зуны цагт халах халууцахын бэрхшээлийг үзэхгүй болохыг магтан дуулсан байна. Шүлгийн дахилгандаа унасан хүний урмыг сэргээж ухаан санааг яруусгах тул зөв

Г.Галбаяр

сайхан ажиллаж амьдарч, хийж бүтээхийн хүсэл зоригийг бадрааж өгдөг шидтэй зуу зуун, мянга мянган жилд ховор төрөх эрэмгий хурдан хүлэг болохыг алдаршуулан дуулжээ.

Зохиолч өөрийн намтар түүхтэй холбоотой зүйлсийг уран дүрслэлийн олон арга барилын хослолоор тодруулан товойлгож бичихдээ ертөнцийн жам хууль, нийгмийн аж амьдралын онцлог, монгол түмний зан заншил, ёс горимын зүй тогтолтой эвсүүлэн найруулж, бие биеийнх нь харилцан шүтэлцээнд урласан нь уран сайхны үүднээс онцлон тэмдэглүүштэй болжээ.

III. Зохиолч Д. Цэдэвийн “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн”

бүтээлийн гүн ухаан

Уран зохиол үнэнийг уран яруу бичих, уран яруугаар дамжуулж утга санааг нээх урлаг. Хүний мөн чанар дахь үнэнийг эрэлхийлэх үзлийг уран сайхны хэлбэрээр илэрхийлж, гүн утга агуулгаар баяжуулан өгүүлж байж сайн зохиол болдог хуультай. Д. Цэдэв зохиолч өөрийн бага залуу цагийн намтар түүхээ өгүүлсэн “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” хэмээх баримтат уран сайхны бүтээлдээ хүний мөн чанар, хүн байгалийн хүйн холбоо хамаарлыг цогцоор нь учир шалтгаант холбоонд нь өгүүлэхийг чухалчилсан нь илт.

III.1. Хүний амьдралын утга учрыг өгүүлсэн нь

Хүн оюун ухаанаараа бусад амьтнаас давуу тул амьдрал нь тэр хэмжээгээрээ бусдаас ялгардаг. Бусад амьтнаас давуу ухаантайн хувьд тэр давуу шинж чанарынхаа хэмжээгээр бас учир битүүлэг далд мөн чанарыг хадгалж байдаг. Амьдрал ахуйнхаа утга учрыг олохоос үүдээд хүмүүсийн хооронд өрсөлдөөн үүснэ. Өрсөлдөөн амьдралыг шударга, утга учиртай болгодог. Хүний амьдралын утга учрыг урлаг уран зохиол ямагт нээж бусдал гарц гаргах үүднээс анхаарлаа хандуулж байдаг. Бидний онцлон үзэж байгаа зохиол ч мөн ялгаагүй энэ асуудалд анхаарлаа хандуулсан байна. Зохиолч өөрийгөө хэрхэн төрсөн тухайг хожим аавынхаа өгүүлсэн дурсамжинд тулгуурлан “*Сэтгэл нь нялхарсан эхийн хэдэнтээ ёолохын сацуу гэрийн баруун хаяанд түсгэйлэн бэлтгэж зассан газарт нялх нялзрай үрийн уйлах дуу час хийв. Ёолох, уйлах хоёр зэрэгцээг орчлонгийн жам*” (85 дугаар тал) хэмээн хүний амьдрал баяр гунигийн торгон зааг дээр оршдог жамтайг илэрхийлсэн хэрэг. Энэ баяр гунигийн тэнг тааруулж амьдрах нь хүний ухааны бядыг шалгадаг шалгуур аж. Учир нь өвдөж зовсон эхэд зовлон шаналантай ч уйлж ирсэн шинэ хүн өөрөөсөө бусдад жаргал бэлэглэн ирсэн нь мэдээж. Тухайн үед өвчин шаналантай ч үрээ хараад эхэд баяр баясал төрөх нь мэдээж. Бусдад баяр жаргал уйлах дуугаараа бэлэглэн ирэх жаалхүү ертөнцийн хатуу хөгүү гадарга дээр эхийн зөөлөн хэвлээс унаж өвдөж зовох нь мэдээж. Энэ бүхэн хүн гөрөөсөө баяр гунигийн уулзварт ирж энэ замаараа замнадаг жамтайг харуулж байна. Зохиолч хүний төрөх, үхэхийн жам хууль, мөн чанарын тухай үзлээ өөрийнхөө өсөлт хөгжилт, эхийгээ алдахын зовлон зүдгүүртэй холбон лавшруулан өгүүлжээ. Лав ээж, ах дүүдээ баяр жаргал дагуулж ирсэн жаалхүү өдөр хоногоор өсөж эр бие тэлж, энэ тэр зүйлийг ухаарах болсон ч дөнгөж тавхан насандаа эхийгээ алдаж хагацлын хар мананд автсан аж. Энэ тухай зохиолд “*Энэ л гэрт хэдэн жилийн өмнө хүү төрж хүй цоглож байхад залуу эхийн сэтгэлд хичнээн хоор баяр ундарч байлаа? Залуу эхийн баярыг хувиалцах гэж хичнээн хүн эсгий гэрийн босго алхан байлаа? Гэтэл өлмий дээрээ гишгэж, бие биендээ үг шивнэх тодий ярилцах ганц нэгэн өвгөжөөр настнаас өөр тэр гэрийн үүд хаалгаар орж гарах нь ор тас хүмүүдэжээ.*” (95 дугаар тал) хэмээн харуусал гуниг нэвт шингээн үнэнд тулгуурлан ертөнцийн хатуу хөгүүг гайхан эргэлзэж хэн нэгнээс хариулт нэхэн өгүүлжээ. Хүний амьдрал баяр гунигийн торгон зааг дээрх замнал. Энэ замналын ончийг тааруулж амьдрах нь хувь хүний хувьд хамгийн том баяр хөөр, ончийг нь үл тааруулж амьдрах нь хамгийн том гуниг харуусал

Г.Галбаяр

төрүүлж байдаг бол бусад хүний хувьд амьдралын их замналын хамгийн том баяр хөөр нь хүн төрөх, хамгийн том гуниг харуусал нь хүн үхэх. Хүний амьдралын энэ мөн чанарыг зохиолч өөрийн намтар түүхэд тулгуурлан олон талын учир шалтгааны холбоо хамаарал дунд нь уран сайхны аргаар өгүүлсэн байна.

Эхлэл үгүй төгсгөл үгүй үргэлжлэх цаг хугацааны дунд шинэ хүн төрж өөрийнхөө хувьд цаг хугацаагаа эхлүүлдэг нь хүний онцлог. Хорвоогийн түмэн амьтан хувь хувьдаа цаг хугацаагаа эхлүүлж бас төгсгөдөг учир ерөнхий их цаг хугацааг үүсгэж тэр нь үл тасалдах үл төгсөх мөн чанарыг үүсгэж байдаг хуулийг зохиолч *“Ерөөл учралын цэг-эхлэл эцэс нь үл мэдэгдэх цагийн урсгалтай нийлсэн хүүгийн шинэ тооллыг дагаж гэр даяар ийн хөл хөдөлгөөн. Хүүг авсан ээж, эцэг хоёр тодийгүй эргэх орчлон ингээж эх барьжээ.”* (86 дугаар тал) хэмээн бодитойгоос бодитой бусыг, бодит бусад бодит үнэнийг шингээн урласан нь хүний мөн чанарын нэгээхэн хэсгийг уран сайхны аргаар тайлбарласны илрэл.

Хүүг төрсний дараа монголчуудын ёс заншлын дагуу тусгайлан чанасан хонины өвчүү, хаа кош, шаант чөмөгний давстай бүлээн шөлнөө будаа, арц хийж түүгээр хүүгийн биеийг угаасан аж. *“Энэ нь давсаар бүртгийг цэвэрлэж, арцаар ариутгаж, үр будаа шиг өнөржин үржихийн бэлгэдэл ажээ.”* (86 дугаар тал) Монголчууд аж амьдралын туршлагаараа давс аливаа зүйлийн хир бүртгийг цэвэрлэх шинжтэй, арц аливаа зүйлийн дотоод мөн чанарыг ариутгах увдистай, будаа аливаа зүйлийг өсгөн үржүүлэхийн бэлгэдэлшинжтэй болохыг ажиглаж ухаарчээ. Энэ нь угтаа бол аливаа зүйл гаднаа хир буртаггүй, дотроо ариун сайхан байж өсөн үржиж, өнө мөнхөд үргэлжлэх ойлголт бэлгэдэлт сэтгэлгээ билээ.

Хүний амьдралын утга учир үр хүүхэд төрүүлж, удам угсаагаа залгамжлуулах. Тиймд хүний хамгийн эрхэм эрдэнэ бол үр хүүхэд. Үр хүүхдээ эрүүл саруул өсгөх, зөв хүмүүжүүлэх, сайн хүн болгох нь хүүхдээ ойлгох, хүндэтгэхээс эхэлдэг болохыг зохиолч *“Миний тунхааныг аав тайлах гэж оролдохгүй дорно хэдэнтээ дэвхцэх гэсэнэ больж үгэнд минь орж унтаад өгнө. Хүүхдийн гараар зангилсан тунхаа ямар л бат бэх байв гэж дээ. Тушааг тайлаад л гараад явчихыг хэн байг гэжэв. Харин аавыг явуулахгүй гэсэн миний сэтгэлийн тунхааг л тайлж болмооргүй байсан байх даа”* (101 дүгээр тал) хэмээн өгүүлжээ. Эцэг эхийн хайранд, тэдний хүндэтгэл итгэлийг хүртэж өссөн хүүхэд хожим эх эцэг, хань үр хүүхдээ, нутаг орноо хайрлан хамгаалж тэдний төлөө зөв сайхан амьдардаг нэгэн болдог. Энэ бол хүний амьдралын чухал мөн чанар.

Хүн аливаа амьдралын явцдаа танин мэдэж, ухаарч, түүнээсээ таашаал таалал эдлэж, тэр таашаал таалал нь дараа дараагийн сайн сайхан зүйлийн шав суурь болж оршдог жамтай. Өнөөдөр хэн нэгний сайн сайхан үйл хэргээр бүтээгдсэн зүйл маргааш дараагийн хүмүүсийн танин мэдэх, ухаарах сэтгэлгээнд үнэтэй хувь нэмэр оруулна. Энэ мэт гинжин хэлхээ хүний аж амьдралын утга учрын нэгээхэн хэсэг. “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” хэмээх зохиолчийн уянгын бодрол-намтрын хуудас болсон зохиолд уртын дууны тухай дэлгэрэнгүй өгүүлсэн тухай өмнө бид бичсэн. Зохиолчийн төрсөн нутаг Нарийны гол төв халхын уртын дууны нэгэн том голомт болохын хувьд уртын дууны ая эгшиг, утга агуулгаас амьдралын их сургамж авч, тэр хэрээрээ нийтийн дунд дэлгэрүүлж, хойч үедээ өвлүүлэн үлдээх дэг сургуулийг үүсгэсэн газар аж. Тиймд зохиолч *“Дуугаар амилсан ертөнц намайг бүрнээ эзэмдэж нүдий минь нээсэн юм. Уртын дуу нь хайрын халуун сэтгэл мэт, идрийн золбоо жавхлан мэт, өвгөдийн сургаал мэт. Уртын дуунд баяр баясал, уйтгар гуниг, ойрын явдал, холын бодол цөм шингэжээ”* (107 дугаар тал) хэмээн чухам голыг нь олж, үнэнийг өгүүлсэн байна.

Хүн өөртөө хамгийн ойр, хамгийн сайн мэддэг зүйлийнхээ тухай яг оносон тайлбарыг хэлэхдээ учир дутагдалтай аж. Магадгүй хүний хамгийн сайн мэддэг зүйл нь хамгийн учир битүүлэг зүйл байдаг биз. Хамгийн ойр байдаг нэгнээ ойлгодоггүй хайрладаггүй ч байж

Г.Галбаяр

мэднэ. Тиймээс ч монголчууд амьдрал дундах энэ үнэнээс ургуулан “*модчны гэрт түлээгүй*”, “*загасчны морь усгүй*” гэх мэтээр сэрэмжлүүлэн өгүүлсэн нь бий. Бидний бодлоор хүн өөрөө өөрийгөө хамгийн муу ойлгодог бололтой. Өөрийгөө ойлгохгүй байгаа хүн бусдыг ойлгоно гэдэг үнэнд үл нийцнэ. Өгүүлэн буй зохиолд энэ асуудлыг нэлээд ул суурьтай хөндөж, өөрөөсөө илүү найз нөхдөө ойлгох, тэр ойлголтоос хүндэтгэлийг төрүүлэхийг чухалчлан бичсэн байна. Тиймд зохиолд ганзага нийлэн аялаж буй багын найз Доржийнхоо тухай өгүүлсэн хэсэгт үерхэл нөхөрлөлийн тухай “*Үерхэл гэдэг олны дотроос хэн нэгнээ ойлгосон санааны ил биш хэрнээ үл тасрах далдын холбоо, цагийн урсгалыг нэвтлэн уртсан сунаж байдаг сэтгэлийн уяа мөн болъюу*” (122 дугаар тал) хэмээн үнэн мөнөөр нь товч тодорхой өгүүлжээ.

Зохиолын төгсгөлд зохиолч төрсөн нутгийнхаа шөнийн саруул тэнгэрийн дор найзын хамт явахдаа төрсөн цагаас эхлүүлэн бүх амьдралаа эргэцүүлэн бодоод өөрийнхөө хэн болохыг өөрөөсөө асуугаад өөртөө “*Би бол хол ойрын сая сая оддын гэрэл нисэн буух нэгэн уулзвар, сарны туяа харван ирэх нэгэн цэг мөн буюу. Би бол сая сая одонд харц илгээх, саран авхайд бодлоо билчээх нэгэн бүлгээ*” (140 дүгээр тал) хэмээн тодорхойлоод эцэст нь “*Алив нэгэн хүний намтрын хуудас ч гэлээ өмнөх үе эцэг эхийн залгамжлал, хойч үе-үр удамд уламжлах үргэлжлэл буюу. Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цаг дөрвөн улирлын сүлжээ хэлхээн дунд хүний нэгэн насны амьдрал урсан урссаар л ...*” (141 дүгээр тал) гэж өгүүлсэн байна. Зохиолч өөрийгөө уран сайхны үүднээс орчлон ертөнц одон гарагийн солбицол дээр аваачин тодорхойлсон нь амьдарсан амьдралын туршлага, ухаарсан ухаарлын илэрхийлэл нь болжээ. Ийнхүү уг зохиол зохиолчийн намтар түүх мөн хэдий ч бусад хүмүүсийн намтар түүхийн нийтлэг хэв загварыг хадгалсан бүтээл, цаг хугацааны гэрч гэдэгтэй санал нэг байна.

III.3. Хүн, байгалийн хүйн холбооны тухай өгүүлсэн нь

Хүн уул ус, байгаль ертөнцтэйгөө хэрхэн холбогддог жам хуулийг “*Газрын судас дамжин хорсноос нэвчсэн тунгалаг ус эхэлж эхийн сүүтэй, энхрий хайртай, хүүгийн нь залгалж уусан унд мөн. Энэ л ус хүүгийн судсаар дамжин гүйсэн цус биз. Энэ л булаг шандны усаар хүүг ариутган угаасан нь мэдээж. Ингэж хүү ус урсгалтай нүүр учирчээ. Энэ бүхэнтэй монгол хүний “угаасан ариун ус” гэж эрхэмлэгдийн учир холбогдол бүлгээ*” (86 дугаар тал) хэмээн өгүүлсэн байна. Энэ нь хүн ертөнцийн хосгүй уран бүтээл тул ертөнцийн ерөнхий хэв загварыг хадгалж, байгалийн хууль жамын дагуу амьдрах ёстойг илэрхийлсэн хэрэг. Хүн байгалийн төгс бүтээгдэхүүний хувьд байгаль дээрээ байгалийн хуулиар амьдардаг тул хүн байгаль хоёр хүйн холбоотой нь ойлгомжтой. Хүн эхийн хэвлийд анх бүтэж бүрэлдэхдээ л ертөнцийн ерөнхий зүй тогтлын хуулинд захирагдаж эхийнхээ амьсгалж байгаа агаар, ууж идэж байгаа унд хоолоор дамжин байгальтай нарийн холбогдож байдаг тул хүн байгаль хоёрын холбоог юугаар ч орлуулах аргагүй юм.

Зохиолч төрсөн нутаг “Улаан дэл”-д өнө мөнхөд орших эхээс мэндэлсэн гэрийнхээ буурин дээрээ аавтайгаа ирж орчин тойрныг нь ажиглаад “*Хээр тал нутгийн намхан дэл хавцгайн дунд миний төрсөн намаржаа байрлажээ*” (88 дугаар тал) хэмээн тодотгон бичсэн байна. Төрсөн гэрийн буурийн орчмоос хоёр жижиг чулуу авч нандигнаад “*Тулгын гурван чулуунаас унасан газар эхэлнэ. Унасан газар шорооноос унаган төрөлх эх нутаг эхэлнэ. Тийм болохоор нутгийн чулууг өвөртлөн явна гэдэг унасан газартайгаа явсагийн бэлгэ тэмдэг мөн. Хэрэв төрсөн газраа үгүйлэн санавал энэ чулуугаа үзэж сэтгэлийн цангаагаа гаргаж болно*” (83 дугаар тал) гэж нутаг орон, эзэн хүнтэйгээ хүйн холбоотой байхын утгыг уран сайхнаар учирлан өгүүлсэн байна. Улмаар “*Миний багадаа ярьсан яриа бүхэн, хэн нэгэнд шоглуулаад уйлсан дуу болгон нутгийн агаар мандлын аль нэгэн давхрагад эсвэл Улаан дэлийн зулсад нарны туяа, сарны гэрлийн хамт хадгалаастай байх вий*” (88 дугаар тал) гэж төрсөн нутаг нь үр хүүхдүүдийнхээ сайн, муу бүх зүйлийг хадгалан оршдог болохыг өгүүлэхийн сацуу хожим

Г.Галбаяр

хүн төрөлхтөн нутаг орондоо шингэж үлдсэн дуу авиа, үйл хэргээ эргүүлэн сонсож, ойлгож чадах хэмжээнд хүртлээ хөгжих боломжтойг зөгнөн хүүрнэсэн нь уран бүтээлч хүний хүсэл мөрөөдөл мөн буюу. Зохиолч цааш нь *“Миний хамгийн анх үзэж авирсан уул бол Улаан дэл. Бусад уулыг үзээгүй байсан надад орчлонгийн хамгийн ондөр хайрхан Улаан дэл байжээ”* (88 дугаар тал) хэмээн өгүүлсэн нь нутгийн уул толгод гэдэг төрсөн хүүдээ ертөнцийн бүх зүйлийг ухааруулж өглөг жамтайг өгүүлсэн хэрэг. Өндрөөд аврихын ухаан, уруу руу буухын арга гээд ертөнцийн тогтолцооны ерөнхий хэв загварыг эндээс эхэлж сурдаг. Эхэндээ бодитоор ууланд авирах, уруудах, өвс ургамал ургах хагдрах гээд бүх зүйлийн бодит зүй тогтлыг ухааруулдаг ч тэр ухаарал төрсөн хүүгийнхээ боловсрол мэдлэг, нас намбын эрхээр хийсвэр төвшинд шилжиж хүн яаж амьдрах ухааны эхлэл, ертөнцийн үнэн мөн чанарыг таниж амьдрахын ундрага болдог үнэнийг урнаар өгүүлжээ.

“Энд миний мор эхэлж гараа. Үзэгдэхгүй л болохоос лав тэнтэр тунтар алхсаны мор энд байгаа. Алхах гэж хичнээн удаа унаж тусгаа бол! Унахдаа алганы хэзгээ газарт гаргаж гараараа хичнээн ч тулж босоо бол. Гарын ямар их тулгуур хүчтэйг анх энд л мэдрээ дээ. Анхны алхам ч, аян замын гараа ч эндээс эхлээ дээ” (89 дүгээр тал) гэж газар нутаг өөрийн төрсөн үр хүүхдэдээ хорвоогийн баяр гуниг, хатуу зөөлний мөн чанарыг багаас нь зөв ухааруулдаг жамтайг урнаар өгүүлжээ. Ертөнц бол өөрийн орших хууль жамтай тэр хууль жамыг зөв таньж, түүнд зохицож амьдрах нь хүний амьдрал. Төрсөн нутгийнхаа мөн чанарыг хэр зөв ухаарна тэр хэмжээгээрээ хүн зөв амьдардаг жамтай. Төрсөн нутгийн тухай ухаарал бол их амьдралын гараа. *“Гараа сайн бол бариа сайн”* гэж монгол хүмүүс хэлдэг нь санамсаргүй хэрэг биш биз.

Зохиолч төрсөн нутгийнхаа тухай элдвийг эргэцүүлэн, олон зүйлийг гүнээ ухаарч байх ахуйд аав нь хүн төрсөн нутаг орноо зөвхөн өөрөө мэдрээд зогсохгүй үр удам хойч үедээ өвлүүлэн үлдээхийн чухлыг *“Энэ газар шорооноо тэдэндээ үзүүнэ гэдэг нутаг нугаа мэдүүлж байгаа хэрэг. Энэ газар шорооны тасархай гэдгээ ч үр хүүхэд чинь мэдэж авна! Тэгээд ч хайрлаж хямгадаж яваг! Зөвхөн хүүхдэд унасан газраа зааж өгч байна гэж явцууран бодож болохгүй. Удам хойч үед өвгөд дээдсийн нутаг нугаа нээж тайлж өгч байна гэж бодогтун”* (91 дүгээр тал) хэмээн сургасан тухай өгүүлжээ. Амьдралын тухай ихийг ухаарсан өвгөдийн энэ мэт үг монгол газар дээр монгол хүний удам тасрах учиргүйн илэрхийлэл. Төрсөн нутаг орноо ариун дагшин хадгалж үлдэхийн тухай их цөлх ухаан.

Сүүлийн жилүүдэд дэлхийн эрүүл мэндийн шинжлэх ухаанд Японы эрдэмтэд нэгэн нээлт хийсэн гэнэ. Хүмүүсийн эрүүл байж урт наслахын үндэс шалтгааны асуудлыг нарийн судлаад эцэст нь хүн эрүүл байж урт насалж байгаагийн нууцыг хүн өөрийн төрсөн нутгийн агаараар амьсгалж, усыг нь ууж, тэр нутгийнхаа хөрс шороонд ургасан ургамал ногоо, тэр нутгийн өвс ногоог идсэн малын мах, сүүг хэрэглэх явдал хэмээн хөдөлгөөнгүйгээр шинжлэх ухааны үүднээс баталсан явдал юм. Энэ судалгаатай холбоотойгоор өдгөө дэлхийн олон орны хүн зон төрсөн нутаг орныхоо хүнс хоолыг илүү чухалчлан үзэх болжээ. Энэ нь цаанаа хүн төрсөн нутаг усныхаа агаар ус, ургамал ногоотой хүйн холбоотой байдгийг харуулж буй хэрэг. Шинжлэх ухааны нарийн судалгаагаар хөдөлгөөнгүй батлагдсан энэ үнэнг аль эрт монгол зохиолч өвөг дээдсийн аж амьдралын онцлог, тэднийхээ байгаль дэлхийтэйгээ харьцах нарийн ур ухаанд дөрөөлөн өөрийн намтар түүхийг өгүүлсэн зохиолдоо *“Монгол хүний биед идэх уух, агаар устай нь уялдсан ургамал амьтны гаралтай эм, нутаг нугын рашаан ус шүү зохимжтой ч байж мэднэ дээ. Гэтэл бид хоол унд нь хөнгөн шингэн, агаар амьсгал нь урин зөөлөн орчины хүн зонд зориулсан эмээр л амаа зайлж, ходоодоо хорсгож байна шүү дээ”* (135 дугаар тал) хэмээн тэртээ 1986 онд бичиж байж. Жинхэнэ байгаль-нийгмийн хослолоос заяасан авьяастай зохиолч байгаль-нийгмийн жам хуулийн дууч байдгийн илрэл энэ. Байгаль-нийгэм өөрөө өөрийнхөө мөн чанарыг тайлбарлуулах, ойлгуулах үүднээс өөрийн дуу хоолой болсон зохиолчоо төрүүлдэг жамтай. Тиймд жинхэнэ сайн зохиолчийн зохиолоос ертөнцийн жам хуулийн мөн чанар, нийгмийн амьдралын зүй тогтлын үнэнийг мэдрэх боломжтой гэж

Г.Галбаяр

онолын хувьд үздэг. Зохиолч, зохиолын энэ онцлогоос үүдсэн зохиолыг үнэний дуу хоолой, цаг үеийн зөнч урлаг хэмээн үздэг нь үндэслэлгүй ойлголт биш юм.

Зохиолч төрж өссөн нутаг орноороо хөндлөн гулд аялаж, нутаг орныхоо хүн зоны аж амьдралтай танилцаад өөрийн бага насны намтар түүхээ нэхэн өгүүлээд хүн байгалийн хүйн холбооны тухай гүнээ нарийн ухаараад *“Тэр л од эрхэс мянгань тэртээгээс намайгаа харж ханддаг гэсэн бодол итгэлээс өнөө болтол салж чаддаггүй юм. Ер нь хүрэх хүслэн, итгэх итгэл, шүтэх шүтээн гэж байхгүйсэн бол хүн гэдэг чинь зөвхөн газрын хэвлийн амьтан болох бус уу?”* (141 дүгээр тал) хэмээн өгүүлж байна. Төрсөн нутаг хүнд хүсэл төрүүлдэг, итгэл бишрэл бий болгодог. Тэр нь эргээд шүтэх шүтээн болж зүрх сэтгэлд нь уягддаг. Хүний зүрх сэтгэлд байгаа энэ уяа хүний амьдралын утга учрыг төрүүлэн хөглөж өгдөг байна. Зохиолчийн төрсөн гэрийн бууринаасаа авахуулаад орчлон хорвоо, одон гаригийн тухай эргэцүүлэл тэмүүлэлээс үзвэл хүн төрөхдөө доод газартайгаа хүйн холбоотой байж ертөнцийн татах хүчний хуулийн дагуу амьдардаг ч хүний ухаан бодол тэлж, мэдлэг боловсрол нэмэгдэхийн хэрээр дээд огторгуй руу тэмүүлж тэр зүгтэй ухаан бодлоороо хүйн холбоотой болдог үнэнийг өгүүлсэн хэрэг.

Зохиолынхоо төгсгөлд *“Би ч гэсэн өөрийн намтрын урсгалын цалгиан халгианаас монгол хүн, нутаг хоёрын шүтэлцээний гинжин холбооны нэгээхэн агшинг өгүүлсэн минь энэ больюу. Чухам үүнээс эх дэлхийн тохмын чинээн зай болсон нутаг нугын шивнээн, төрсөн үрийн сэтгэлээр дамжин бүдэг ч гэсэн сонствоос газар шороо, ус голоо гэсэн халуун сэтгэлт хүний итгэл энэрлийн зүрхэн тольтод ганц ч болов хэм нэмэх болтугай хэмээсэн чин хүслэн минь биелэхийн үүдэл болой”* (142 дугаар тал) хэмээн өөрийн намтар түүхээр дамжуулан хүн байхын мөн чанар, хүн байгалийн хүйн холбооны учир утгыг өгүүлж, хойч үеийн хүүхэд залууст сургамж болон сэтгэлийн гүнд нэгийг бодогдуулан нутаг орноо хайрлах ухаарлыг төрүүлжээ.

Г.Галбаяр

ДҮГНЭЛТ

Хүний мөн чанарг аливаа зүйлийн үнэнийг чухалчлах, ямагт сайхан руу тэмүүлэх, ямар нэг зүйлийн мөн чанар, учир зүйг зөв таньж ухаарах бодол шингээстэй байдаг байна. Уран зохиол хүнд өөрийг нь нээж, ухаарал бэлэглэгч урлагийн хувьд үнэн, уран сайхан, гүн ухааны хэм тэгш төгс хослолд оршдог. Үнэнийг уран сайханжуулж, уран сайхныг утгажуулсан төгс холбоос бий болж байж тухайн зохиол үнэ цэнэтэй.

Бид энэ удаад зохиолч Д. Цэдэвийн “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” зохиолыг үнэн, уран сайхан, гүн ухааны хослолын үүднээс задлан шинжилж үзээд доорх дүгнэлтэд хүрэв.

Зохиолч “Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” бүтээлдээ өөрийн бага залуу цагийн намтар түүхийн үнэнг уран сайхны хэлбэрээр өвөрмөц уран зохиомжийн аргаар дүрслэхдээ хүний амьдрал, орчлон хорвоогийн дотоод мөн чанар дахь олон зүйлийн ухаарал тайлбараар шигтгэл, холбоос хийж өгүүлсэн нь зохиолын үнэ цэнэд чухлаар нөлөөлжээ.

Зохиолч өөрийнхөө бага залуу цагийн намтар түүхийн үнэнг уран сайхнаар дүрслэхдээ гүн утга агуулгыг шингээж урласан нь тухайн зохиолчийн аж амьдралын онцлог болоод зогсоогүй нийт олны аж амьдралын ерөнхий хэв шинж болсноороо энэ зохиол ихээхэн онцлогтой болсон байна. Энэ нь Д. Цэдэв гэдэг хүний бага залуу цагийн намтар түүхийн урлал болоод зогсоогүй ерөөс монгол хүний аж амьдрал, намтар түүхийн нийтлэг онцлогийг баримтат уран сайхны аргаар хүүрнэхийн гөлөөлөл болжээ. Тиймд уг бүтээл монголын уран зохиолын түүхнээ чухал байр эзэлнэ.

“Гал голомт буюу нутаг нугын минь шивнээн” бүтээлд жинхэнэ яруу сайхан зохиолд байвал зохих үнэн, уран сайхан, гүн ухааны хэм тэгш хослолоор хүний амьдралын утга учир, мөн чанарыг бодитой бичиж, түүхэн уран сайхны дүрийг урлаж чаджээ.

Зохиолч өөрийн амьдралд цагаасаа эрт тохиолдсон хагацал өнчрөлийн тухай бичсэн хэсгүүдэд хүн хийгээд ергөнцийн амьдралын утга учрыг илүүтэй учирлан өгүүлсэн бол баяр хөөр, сайн сайхны тухай өгүүлсэн хэсгүүдэд дэврүүн өөдрөг уран хурц дүрслэлүүдийг гаргажээ. Зохиолчийн үзэл бодлын дотоод мөн чанар, гадаад баяр баясгалан ямагт намтар түүхийн бодит үнэнд зангилагдан өрнөсөн нь энэ зохиолын онцлог болжээ.

Зохиолч төрсөн нутгийнхаа сайхан сэтгэлт, сайн үйлт хүн ард, эрэмгий хурдан эрдэнэт хүлэг морины шинж чанар, үйл амьдралын замналаар нутаг орныхоо байр байдал, онцлог мөн чанарыг тодруулан гаргаж дүрслэсэн нь монголын утга зохиолын түүхэнд тэр бүр үзэгдээгүй уран сайхны өвөрмөц арга болсон байна. Өөрөөр хэлбэл бүх зүйл нь төгс зохист нутагт сайн хүн, сайхан хүлэг төрж өсдөг жамтайг хүн ардынх нь аж амьдрал, уужуу тайван ухаан, хүлэг морьдынх нь эрэмгийн чадал, хурд хүчээр дамжуулан илэрхийлж чадсан хэрэг.

Уг зохиолоор дамжуулж хүний мөн чанар, хүн-байгалийн хүйн холбооны нарийн нандин олон асуудлыг хөндөж, монгол малчин хүний аж амьдрал болоод оюуны дархлаа, монгол эх орны үнэ цэнэ өчигдөр хэрхэн ойлгогдож байсан, өнөөдөр хэр ухаарагдаж байгаа, маргааш яаж хайрлагдах хүндлэгдэхийг өгүүлсний хувьд нэн өвөрмөц юм.

АШИГЛАСАН БҮТЭЭЛҮҮД

1. Байгалсайхан С. *Уран дүрийн онолын лекцүүд*. Уб., 1998
2. Байгалсайхан С. *XX зууны монгол өгүүллэгийн туурвил зүй*. Уб., 2011
3. Гаадамба Ш. *Утга зохиолын онолын үндэс*. Уб., 1989
4. Галбаатар Д. *Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны найлбар толь*. Токио., 2002
5. Галбаяр Г. *Уран зохиол шинжлэлийн лекц*. Уб., 2002
6. Галбаяр Г. *XX зууны монголын уран зохиолын хөгжлийн үе шатууд*. Уб., 2004
7. Гэрэлтү Б. *Монгол зохиолын онолын чимэг*. Хөх хот., 1985
8. Дашбалбар О. *Цаг цагийн урсгал буюу Дожоогийн Цэдэв*. Зохиот аялгуу. 1991., №18 (23)
9. *Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх*. Уб., 1968
10. *Монголын орчин үеийн уран зохиолын түүх*. I-III боть. Уб., 1985, 1989, 1998
11. *Монголын уран зохиолын дээжис*. СIII (103) боть. Д. Цэдэв *Тэд нүдэлсэн агь*. Уб., 2004
12. Нарантуяа Р. *Эрдэмтэн зохиолч Дожоогийн Цэдэвийн уран бүтээлийн онго аяс ба урлах эрдэм*. Уран зохиол судлал. Том 8 (XXV) 1-23. Уб., 2001
13. Хүрэлбаатар Л. *Судар шастирын бичиг*. Уб., 2002
14. Хүрэлбаатар Л. *Дуун, утгын яруу зохиот*. Уб., 2005
15. Цэдэв Д. *"Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл*. Уб., 2002
16. Цэнд Д. *"Сэвтээ нь үгүй сэтгэл"* дууны үгийг бичигч. Уран зохиол судлал. Том 6 (XXIII). 1-17. Уб., 1999

Г.Галбаяр

SUMMARY

Not only does a literary work excite the reader's imagination but also it brings new ideas and hopes to his/her mind. And each school of literary thought has sought to find out that powerful tool which appeals to the reader. And it is those stories which tell truth and reflect reality that are deemed to attract the reader's interest and appeal to them. Although the reality and truth appeal to the reader, they equally appreciate fictional sub-stories and descriptions that grow out of the story itself. The Literature as a blend of language and composition, should draw the reader's attention when it finds its form based on reality. As a rule, human nature aspires for beauty and the good. The Literature is a realization of that aspiration based on reality.

Therefore, the issue of poetry and lyrics is as equally important as the issue of reality. By feeling sensations from reading such as happiness, sadness or repulsion, the readers take lessons for themselves and open their inner worlds. The story's various plots and dramatic structure define the reader's inner appreciation of the story. And these inner rhythms inside the reader's mind that make him/her open subconscious qualities inside them about life and its value. And the writer offers his/her hints about life and his vision of reality through literary description using different paces, links and dramatic decisions. The Philosophical prisms in the stories that explain and describe the plot can also serve as the basis of the novel. Any novel becomes a good piece of art if the reality is transformed into prose and prose is based on logic. Therefore, it can be said that a good novel is combination of Reality, Poetry and Philosophy.

We would like to briefly examine D.Tsedev's "The Family Hearth or The Wispers from My Birthplace" and how this work reflects the above-mentioned three prisms. D.Tsedev's "The Family Hearth or The Wispers from My Birthplace" has another subtitle – "Poetic Thoughts –Biographical Notes". The subtitle implies that the author attempts to reflect on his life and biography through poetry. The work consists of the prologue called "The Wispers from My Birthplace", first chapter called "Offering backing to my Father", second chapter - "Working in Harmony with my Friend Dorj" and Concluding words.

In "The Family Hearth or The Wispers from My Birthplace" the author tells the true story of his childhood and adolescence using literary techniques and it can be said the work possesses all three qualities. The author tells his true childhood story coupled with observations from real life situations. The story touches upon the issues such as human life and human nature; connection between man and mother nature; the livelihood of the Mongolian nomads and their spirituality; the past, present and future of Mongolia.